



ӨМНӨГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

20²⁵ оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/15

Даланзадгад сум

“Сүү, тараг хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил, дархлааг амин дэмээр баялаг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах замаар эрүүл өсөж торних боломжийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулах зорилготой “Сүү, тараг” хөтөлбөрийг хавсралтаар баталсугай
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгаж, үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д даалгасугай.
- Эрүүл мэндийн салбар, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын оролцоонд тулгуурлан хөтөлбөрийг хэрэгжүүлж, үр дүнг нэгтгэн жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга (Н.Энхбат)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

О.ЭРДЭНЭ-ӨРНӨХ



4625010048

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн
4/15 дугаар тогтоодын хавсралт

“СҮҮ, ТАРАГ” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Хүн амд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, өвчлөл, нас барагтын тэргүүлэх шалтгааныг бууруулах, урьдчилан сэргийлэх, иргэдийг эрүүл дадал хэвшил төлөвшүүлэх чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Өсөлттэй Өмнөговь” үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт арга хэмжээг тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Үндэсний хэмжээний бодлого хөтөлбөрийн дараах хэсгүүдэд иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, бага насны хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжиж, хүүхдийн өсөлтийн хоцрогдол, өвчлөлийг бууруулах чиглэлээр зорилт арга хэмжээ тусгагдсан.

Тухайлбал: “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 2.2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1.1 дэх хэсэгт “Эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн эрүүл мэндийн чанар, хүртээмж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, эрүүл амьдралын хэв маяг, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийг дэмжсэн нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бүрдүүлж, санхүүжилт, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэл тусгагдсан.

Хүний хөгжлийн хамгийн эрчимтэй, чухал үе болох бага насны хөгжил, боловсролыг дэмжих нь насан туршийн ухаалаг хөрөнгө оруулалт болохыг орчин үеийн олон судалгаа нотолж байна. Бага насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хамгаалал, хөгжил боловсролыг нэгдмэл хандлага, арга зүйгээр дэмжиж ажиллах нь дэлхий нийтийн төдийгүй Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх зорилтуудын нэг болж байна.

Бодлогын баримт бичигт зургаа хүртэлх насны хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, халамж асаргаа, хамгаалал, хөгжил, боловсролын зорилтуудыг илрүүлэх үзүүлэлтийн хамт нарийвчлан тусгасан байдаг.

Өмнөговь аймгийн хэмжээнд 2024 онд нийт 1190 эх төрж 1198 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 210 төрөлтөөр хүн амын төрөлт буурсан байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1:1.1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Төрөлтийн түвшин буюу 1000 хүн амд ноогдох төрөлт 2023 онд 19 байгаа нь улсын дундгийн түвшинд байгаа ба аймгуудын дунджаас 2-р өндөр хэдий ч өмнөх онуудаас буурах хандлагатай байна.

Жил бүр ихэр төрөлт бүртгэгддэг ба хамгийн өндөр нь 2013, 2018, 2021 онуудад 17 ихэр буюу 34 ихэр хүүхэд төрсөн байна.

Хүүхдийн эрүүл мэнд бол зөвхөн өвчин эмгэггүй байх төдийгүй бие маходын, сэтгэцийн, оюуны, нийгмийн болон сэтгэл санааны эрүүл саруул байдал юм. Хүүхэд эрүүл байх нь гэр бүл, эргэн тойрныхоо томчуудаас ихээхэн хамааралтай. Бие маходын болон сэтгэхүйн аливаа дарамт, хүчирхийлэл, гэмтэл бэртэлгүй, хүүхэд насандаа хуримтлагдсан амьдралын хэв маяг хожим насандаа хүрэх үед таргалалт, амны хөндийн өвчинүүд, чихрийн шижин гэх мэт олон төрлийн архаг өвчинүүдээс ангид байх боломжийг бүрдүүлж өгнө.

Хүүхдийн төрөх үеийн жин нь жирэмсэн үеийн эхийн эрүүл мэнд, хоол тэжээлийн байдал, хүүхдийн амьдрах чадвар, өсөлт хөгжилт, цаашдын эрүүл мэндийн байдал, сэтгэхүйн ба нийгэмших хөгжлийн чухал үзүүлэлт болдог. Бага жинтэй төрөлт (2500 граммаас бага) нь хүүхдийн эрүүл мэндэд олон төрлийн ноцтой эрсдэл учруулдаг. Ураг байх явцдаа хоол тэжээлийн дуталтай байсан хүүхдүүд амьдралынхаа эхний өдөр, сар, жилүүдэд нас барах эрсдэл өндөр байдаг. Амьдарч чадсан хүүхдүүд дархлаа сүлттай, амьдралынхаа туршид булчингийн сул хөгжилтэй, хоол тэжээлээс хамааралт эмгэгтэй хэвээр үлдэх магадлалтай бөгөөд хожим нь чихрийн шижин, зүрхний өвчинөөр өвчлөх өндөр эрсдэлтэй байдаг.

Бага жинтэй төрсөн хүүхдүүд нь оюуны чадамжийн түвшин (IQ) багатай, оюун ухаан, сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй болох эрсдэлтэй ба энэ нь тэдний сургуульд суралцах чадвар, насандаа хүрсэн үед нь хөдөлмөрийн бүтээмжид сэргэөр нөлөөлнө. Бага жинтэй төрөлт нь эхийн эрүүл мэнд, хоол тэжээл хангалтгүй байхаас үүдэлтэй.

Нялх, бага насны хүүхдийг эгзэгтэй үе буюу төрөх үе болон 2 нас хүртэл нь насандаа тохируулан зөв хооллох нь тэдний хэвийн өсөлт, хөгжлийг дэмжихэд шийдвэрлэх үүрэгтэй. Хүүхдийг 6 сар хүртэл эхийн сүүгээр дагнан хооллож, 2 нас хүртэл эхийн сүүгээр

үргэлжлүүлэн хооллох нь тэднийг халдвараас хамгаалах, хоол тэжээлийн төгс эх үүсвэр болохоос гадна эдийн засгийн хувьд хэмнэлттэй, аюулгүй байдаг.

Гэсэн хэдий ч олон эхчүүд хүүхдээ эрт амлуулахгүй, б сар хүртэл зөвхөн эхийн сүүгээр дагнан хооллохгүй, эсвэл хөхнөөс нь хэт эрт гаргах тохиолдол оршиор байна. Үүний улмаас хүүхдээ нялхсын сүүн тэжээлээр хооллож, энэ нь хүүхдийн өсөлт удаашрах, бичил тэжээлийн дуталд өртөхөд нэлөөлж байна.

Мөн аюулгүй үндны усны хангамж байхгүй тохиолдолд хүүхдийг сүүн тэжээлээр хооллох нь эрүүл ахуйн хувьд аюулгүй байж чаддаггүй юм. Хүүхдийг эхийн сүүгээр үргэлжлүүлэн хооллохын зэрэгцээ б сартайгаас аюулгүй, насанд нь тохирсон өтгөн, өтгөвтөр нэмэгдэл хоол өгч эхлэх нь 2 нас хүртэлх хугацаанд тэднийг өсөлт хоцролтоос сэргийлэхийн зэрэгцээ, бие махбодын хэвийн өсөлт, эрүүл мэндийг дэмжинэ.

Аймгийн хэмжээнд “Сүү, тараг” хөтөлбөр 2021-2024 онд амжилттай хэрэгжиж зорилтот бүлгийн 24310 хүүхдийг хөтөлбөрт хамруулсан. Хөтөлбөр хэрэгжих хугацаанд нийт 15 сум, 3 өрхийн ЭМТөвүүдийн харьяа 06-12 сартай 16981 хүүхэд, 2 хүртэлх насны ихэр 897 хүүхэд, 12 хүртэлх насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй 3975 хүүхэд, жингийн алдагдал өсөлт хоцрогдолтой 3199 хүүхэд нийт давхардсан тоогоор 25014 хүүхэд хамрагдахаас 24310 хүүхэд буюу 93,4% -нь сүү, тараг хөтөлбөрт хамрагдсан.

Хамрагдсан хүүхдүүдэд 48520,8 литр сүү, 60818,4 литр тараг, бусад цагаан идээг сонголтоор авч, 7 хоног болгон хөтөлбөрт хамруулсан. Сүү тараг хөтөлбөрийн хүрээнд 2021-2024 онд 771,514,270 төгрөгийг орон нутгийн төсвөөс зарцуулсан. Хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэгч, үйлдвэрлэгч 60 гаруй аж ахуйн нэгж, иргэнийг дэмжин хамтарч ажилласан. Жил болгон “Сүү, тараг” хөтөлбөрөөс хүүхдийн зуны сувиллыг өрх, сумын эрүүл мэндийн төв зохион байгуулж жингийн алдагдалтай, хөгжлийн бэрхшээлтэй, зорилтот бүлгийн хүүхдүүдийг хамруулан асаргаа сувилгаа болон хоол эмчилгээ, витаминжуулалт, бария засалд 2000 гаруй хүүхдийг хамруулан, эмчлэн эрүүлжүүлж ажилласан.

Сүү, тараг хэрэглэснээр хүүхдүүдийн амны хөндийн эрүүл мэнд, ерөнхий эрүүл мэндийн байдал сайжирсан (60,3%), хэвийн (39,4%), нийт хүүхдүүд дунджаар 1.1-1.3 кг жин нэмж, 2,6-3 см өндөр өссөн үр дүнтэй хэрэгжүүлсэн.

Амьдралынхаа эхний жилүүдэд хоол тэжээл сайтай байх нь бие махбодын болон оюун ухаан, сэтгэхүйн зохистой хөгжлийг хангах, цаашдын урт хугацааны эрүүл мэндийн байдлыг тодорхойлох чухал ач холбогдолтой.

Хоол хүнсний хангамж сайн, өвчлөмтгий бус, асаргаа сувилгаа сайн байгаа тохиолдолд хүүхдийн өсөлт хөгжилт боломжит хэмжээнд хүртлээ хөгждөг бөгөөд түүний хоол тэжээлийн байдал сайтай гэж үздэг. Тав хүртэлх насны хүүхдийн нас баралтын 35% нь хүүхдийн хоол тэжээлээс хамааралт эмгэгтэй холбоотой гэсэн тооцоо байдаг. Хоол тэжээлийн дуталтай хүүхдүүд зонхилон тохиолдох хүүхдийн өвчний улмаас эндэх магадлал илүүтэй байдаг ба амьд үлдсэн хүүхдүүд нь дахин давтан өвчлөлд нэрвэгдэж, өсөлт хөгжилт нь доройтдог. Хоол тэжээлийн хөнгөн болон хүндэвтэр дуталтай хүүхдүүдэд ихэвчлэн энэхүү эмзэг байдалтай холбоотой шинж тэмдэг илэрдэггүй.

Бага насны хүүхдийн өсөлт хөгжилт, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн хоол тэжээлийг дэмжиж чанарлаг, амин дэмээр баялаг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж, сувиллын үйлчилгээг үзүүлснээр бие бялдрын өсөлт, дархлааг дэмжиж хүүхдийн өсөлтийн хоцрогдол, өвчлөлийг бууруулахад “Сүү, тараг” хөтөлбөр нь чухал ач холбогдолтой юм.

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Өсөлттэй Өмнөговь” хөтөлбөрийн 2.2.1.13 дахь заалтад Эх хүүхдийн хоол тэжээлд дэмжлэг үзүүлэх “Сүү, тараг” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр тусгагдсан зорилт арга хэмжээг өмнөх туршлага, чадавх дээрээ тулгуурлан хэрэгжүүлж, хөтөлбөрийг ирэх 2024-2028 онд бага насны хүүхдийн өсөлт хөгжилт, хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн хоол тэжээлийг дэмжиж чанарлаг, амин дэмээр баялаг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж, сувиллын үйлчилгээг нэмэгдүүлэх, хүүхдийн өсөлтийн хоцрогдол, өвчлөлийг бууруулах чиглэлээр хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Бага насны болон хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаатай хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил, дархлааг дэмжин амин дэмээр баялаг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангаж, сувиллын үйлчилгээг үзүүлснээр бие бялдрын өсөлт хөгжил, өвчлөлийг бууруулна.

Гурав. Хөтөлбөрийн зорилт

Зорилт 1. Бага насы 06-12 сартай хүүхэд, 12 хүртэл насы хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2 хүртэл насы ихэр хүүхэд, 12-24 сартай жингийн алдагдалтай (тураалтай, туранхай), өсөлтийн хоцролтой хүүхдийг сүү, сүүн бүтээгдэхүүнээр хангах.

Зорилт 2. Бага насы хүүхэдтэй эцэг, эх, асран хамгаалагчдад хоол тэжээл, асаргаа сувилгаа, хооллолтын дадал, эрүүл мэндийн мэдлэг боловсролыг нэмэгдүүлж, эрүүл зан үйл төлөвшүүлэх.

Зорилт 3. Төр хувийн хэвшлийн түншлэл хамтын ажиллагааны хүрээнд сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдал, үйлдвэрлэлд хяналт тавих.

Дөрөв. Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилтот бүлэг

4.1. Бага насы 06-12 сартай хүүхэд

4.2. 12 хүртэлх насы хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд

4.3. 2 хүртэлх насы ихэр хүүхэд

4.4. 12-24 сартай жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролтой хүүхэд

Тав . Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1 Хөтөлбөрийн 4.1. дүгээр зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

5.1.1. “Сүү, тараг” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг аймаг, сумын Засаг даргын захирамжаар баталж, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих, төрийн болон төрийн бус байгууллага, хамтрагч талуудын түншлэл хамтын ажиллагааг сайжруулах;

5.1.2. Зорилтот бүлгийн (6-12 сартай, 2 хүртэлх насы ихэр хүүхэд, 12 хүртэлх насы хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй, 12-24 сартай жингийн алдагдалтай (тураалтай, өсөлт хоцрогдолтой) хүүхдийн судалгааг сүм өрхийн эмнэлэг, халамжийн байгууллагатай хамтран хүүхдийг нэрээр гаргах, шилжилт хөдөлгөөн хийх, баталгаажуулах, мэдээг сар бүр гаргах, цахимжуулах;

5.1.3. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн хүүхдийг сүм, өрхийн эмчийн үзлэлт хамруулж, сүү, тараг олголтын дэвтэр олгох, тэмдэглэгээ хийх, баталгаажуулах, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллээр хангах;

5.1.4. Бага насы 06-12 сартай хүүхэд, 12 хүртэл насы хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2 хүртэл насы ихэр хүүхэд, 12-24 сартай жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролтой хүүхдийг сүү, сүүн бүтээгдэхүүнийг олгох, хяналт тавих;

5.1.5. Хөтөлбөрийн үр дүнг 2 жил тутамд хөндлөнгийн мониторинг хийж дүгнэлт гаргаж тайлгнах.

6.1 Хөтөлбөрийн 4.2. дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

6.1.1. Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагатай хамтран иргэд, эцэг, эх, асран хамгаалагчдад хүүхдийн зөв хооллолтын талаарх мэдээлэл сургалт сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол хүргэх;

6.1.2. Эрүүл мэндийн байгууллага нь өрх гэр, олон нийтэд түшиглэсэн бага насы хүүхдийн хооллолт, хоол тэжээл, нэмэгдэл хоолны талаар сургалтуудыг тасралтгүй зохион байгуулах, эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлт, ашиглалтыг сайжруулах, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх,

6.1.3. Зуны улиралд хүүхдийн сувиллын үйл ажиллагаа явуулах, чийрэгжүүлэх, асаргаа сувилгааны талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх;

6.1.4. Эцэг эх, асран хамгаалагчдын сэтгэл ханамжийн судалгааг жилд 1 удаа үнэлж, дүгнэлт гаргана.

7.1 Хөтөлбөрийн 4.3. дугаар зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

7.1.1. Хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал, хүүхдийн сүүний газрын эрхлэгч, үйлдвэрийн ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулахыг дэмжих;

7.1.2. Эрүүл мэндийн төвүүд, төрийн байгууллага, хамтрагч тал, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, хуулийн хүрээнд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, хамтран ажиллах гэрээ хийх;

7.1.3. Бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж, сүүний ферм, сүү түгээгч иргэдийн бүтээгдэхүүний чанарын баталгаажилт, малын шинжилгээ, ажилчдын эрүүл мэндийн шинжилгээний бичиг, холбогдох шаардлагатай бичиг, баримтын хяналт хийх;

7.1.4. Сүү, сүүн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, үнийг тогтвортой байлгах;

7.1.5. Сүү, сүүн бүтээгдэхүүн олгож буй аж ахуй нэгж байгууллагууд, эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт хийж, зөвлөгөө, зөвлөмжөөр хангах.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжих хугацаа

6.1 Хөтөлбөрийг аймгийн хэмжээнд 2025-2028 онд үе шаттай хэрэгжүүлнэ. (жил бүр 5 дугаар сарын 1-ээс 10 дугаар сарыг дуустал, 6 сарын хугацаанд хэрэгжинэ)

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

7.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

7.1.1. Улсын болон орон нутгийн төсөв

7.1.2. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив

7.1.3. Бусад эх үүсвэр

Найм . Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааны нэгдсэн удирдлага, зохицуулалтыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Нийгмийн бодлогын хэлтэс) хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, мэдээллээр хангах, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжүүлэх, хяналт тавих, тайлагнаж ажиллах чиг үүргийг Эрүүл мэндийн газар хариуцан гүйцэтгэнэ.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, үүрэг

9.1. Сумын Засаг даргын Тамгын газар:

9.1.1. Сүү, нийлүүлэх аж ахуй нэгж, иргэнийг сонгон шалгаруулах, хамтран ажиллах гэрээ байгуулах, ажлын хэсгийг бодлого арга зүйгээр хангах;

9.1.2. Хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд дэмжлэгт удирдлагаар хангах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх;

9.1.3. Сайн, шинэлэг санааг нэвтрүүлэн хэрэгжүүлэх, сурталчлах, мэдээлэх;

9.1.4. Зорилтод бүлгийн иргэдийг бүрэн хамруулахад хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллах;

9.1.5. Хөтөлбөрийн үйл ажиллагаа олон нийтэд сурталчлах, мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх;

9.1.6. Зуны улиралд хүүхдийн сувиллын үйл ажиллагаа явуулахад төсөв санхүү, удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах;

9.1.7. Хүүхдийн сүү, сүүн бүтээгдэхүүний аюулгүй байдал, хүүхдийн сүүний газрын эрхлэгч, үйлдвэрийн ажилчдыг мэргэжлийн сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлж, үнийг тогтвортой байлагахад гүйцэтгэгч талтай хамтран ажиллах;

9.1.8. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангулан ажиллах.

9.2. Эрүүл мэндийн газар:

9.2.1. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, тоон мэдээг нэгтгэж тайлагнах, нотолгоонд суурилсан судалгааг хийх, бүх шатны байгууллагуудыг мэдээллээр хангах;

9.2.2. Сүү, сүүн бүтээгдэхүүний чанар, хүнсний эрүүл ахуй, химийн болон бусад амт оруулагч нэмэлт бүтээгдэхүүн хэрэглээгүй, найрлагад хяналт тавих, зөвлөмжөөр хангах;

9.2.3. Сүү, Сүүн бүтээгдэхүүний шинжилгээ, нийлүүлэгч аж ахуй нэгжид хамтарсан хяналт үнэлгээг хийх;

9.2.4. Зорилтод бүлгийн иргэдийг бүрэн хамруулахад хяналт тавьж, дэмжлэг үзүүлж хамтран ажиллах

9.2.5. Хөтөлбөрийн үйл ажиллагаа олон нийтэд сурталчлах, мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх

9.2.6. Судалгааг авч хөтөлбөрийн үйл ажиллагааны үр дүнг нэгтгэн аймгийн ЗДТГ болон харьяа дээд байгууллагад тайлагнаж ажиллах.

9.3. Сум, Өрхийн эрүүл мэндийн төв:

9.3.1. Сум, өрхийн эрүүл мэндийн төвийн эмнэлгийн эмч, мэргэжилтэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд тодорхой албан тушаалтанд хариуцуулах, байгууллагуудыг арга зүйгээр хангах;

9.3.2. Хөтөлбөрт хамрагдах зорилтот бүлгийн хүүхдийг сум, өрхийн эмчийн үзлэгт хамруулж, сүү тараг олголтын дэвтэр олгох, тэмдэглэгээ хийх, баталгаажуулах, эрүүл мэндийн зөвлөгөө мэдээллээр хангах;

9.3.3. Өөрх, сумын эмнэлэг хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн өсөлтийг тодорхой давтамжтай үзэж үнэлэх, дэвтэрт тэмдэглэх, тоон мэдээг сар бүр үнэн зөв гаргаж ЭМГ-т мэдээлэх, хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн эрүүл мэндийн мэдээллийн сан үүсгэх;

9.3.4. Бага насын 06-12 сартай хүүхэд, 12 хүртэл насын хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, 2 хүртэл насын ихэр хүүхэд, 12-24 сартай жингийн алдагдалтай, өсөлтийн хоцролтой хүүхдийг сүү, сүүн бүтээгдэхүүнийг олгоход хяналт тавих;

9.3.5. Хөтөлбөрийн үйл ажиллагаа олон нийтэд сурталчлах, мэдээ, мэдээллийг тогтмол хүргэх;

9.3.6. Иргэд, эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн зөв хооллолтын талаарх мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэх, эрүүл зан үйл төлөвшүүлэх арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулах;

9.3.7. Эрүүл мэндийн байгууллага нь өрх гэр, олон нийтэд түшиглэсэн бага насын хүүхдийн хоол тэжээл, нэмэгдэл хоолны талаар сургалтуудыг тасралтгүй хийх, мэдлэг хандлагыг сайжруулах, эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлт, ашиглалтыг сайжруулах;

9.3.8. Зуны улиралд хүүхдийн сувиллын үйл ажиллагаа явуулах, чийрэгжүүлэх, асаргаа сувилгааны талаарх мэдлэг боловсролыг нэмэгдүүлэх.

9.4. Хүнс хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар:

9.4.1. Сүү, Сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж, иргэдийн судалгааг гаргах, хөтөлбөрийн ажлын хэсэгт зөвлөх;

9.4.2. Сүү, тарагны үйлдвэр, цех шинээр байгуулахад бизнес эрхлэгчдэд мэргэжлийн зөвлөмжээр хангах, хүчин чадал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох;

9.4.3. Бүтээгдэхүүн нийлүүлэх аж ахуй нэгж, үйлдвэрлэгчийн үйлдвэрлэл, бүтээгдэхүүний чанар стандартад хяналт тавих;

9.4.4. Бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулан ажиллах.

Арав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

10.1 Хөтөлбөрийн хэрэгжилтийг сар бүр эрүүл мэндийн төвүүд аймгийн Эрүүл мэндийн газар, харьяа сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнаж, Эрүүл мэндийн газар хяналт тавьж ажиллана.

10.2 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг жил бүр аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох хэлтэс хариуцан зохион байгуулна.

10.3 Хөтөлбөрийн хэрэгжилтэд үр дунд сууринсан явцын болон хөндлөнгийн үнэлгээг жил бүр хийлгэнэ.

10.4 Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хэрэгжилтийн тайланг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна

Арван нэг. Хөтөлбөрөөс гарах үр дүн, шалгуур үзүүлэлт

11.1 Эрүүл мэндийн байгууллагаас хүүхдийн эрүүл мэндийн байдалд тогтмол хяналт тавьж, хоол тэжээлийг дэмжсэнээр бага насын хүүхдийн өсөлт, хөгжилтийг дэмжиж, суурь өвчлөлийг бууруулах;

11.2 Сүү, сүүн бүтээгдэхүүнийг өдөр бүр тогтмол хэрэглэнээр цус багадалт, өсөлт, хоцрогдол, хоол тэжээлийн дутлаас үүсэх өвчлөлийг бууруулах, шүдний өвчлөлөөс урьдчилан сэргийлэхэд томоохон дэмжлэг үзүүлнэ;

11.3 Бага насын хүүхдүүд сүү, сүүн бүтээгдэхүүнээс нэг өдөрт авах норм, амин дэм авахад дэмжлэг болно.(1 өдөрт 200 грамм сүү сүүн бүтээгдэхүүн хэрэглэх нормтой, 200 гр эко сүү, сүүн бүтээгдэхүүнээс хүүхэд шаардлагатай амин дэмийг авдаг);

11.4 Хөтөлбөрт 12-24 сартай туралтай, туралтай, өсөлтийн хоцрогдолтой хүүхдүүд хамрагдах бөгөөд тэдгээр хүүхдүүдийн 50-аас дээш хувийг дээрх шалтгаанаас гаргах зорилгоор ажиллана;

11.5 Сүү, тараг хөтөлбөрийг өмнө хэрэгжүүлсэн туршлагад суурilan шинэлэг байдлаар хэрэгжүүлнэ. (Цахим бүртгэлийн систем, сар бүрийн мэдээг инфографик ашиглан мэдээлэх);

11.6 Орон нутгийн сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэгчдийг бодлогоор дэмжих, сүүний үйлдвэрлэгчдийг нэмэгдүүлэх боломжтой болно;

11.7 Зуны сувилалтай хавсарч хэрэгжүүлснээр бага насын хүүхдийн биеийн дархлаа сайжруулж эрүүлжүүлнэ;

СҮҮ ТАРАГ ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжийн нэгж	Суурь үзүүлэлт (2024)	Хүрэх түвшин				Тайлбар
				2025	2026	2027	2028	
1.	Сүү тараг хөтөлбөрт хамрагдсан хүүхдийн тоо	тоо	7443	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр	Тухайн жилийн хамрагдвал зохих хүүхдийн тоо
2.	Хөтөлбөрт хамрагдаж байгаа нийт хүүхдийн хамрагдалтын хувь	Хувь	93,5%	100%	100%	100%	100%	
3.	Хөтөлбөрт хамрагдаж жингийн алдагдаас гарсан хүүхдийн эзлэх	Хувь	60%	65%	70%	75%	80%	Жингийн алдагдалтай хүүхдийн тооноос тооцох
4.	Хөтөлбөрт хамрагдаж байгаа хүүхдийн асран хамгаалагчдын сэтгэл ханамжийн хувь	Хувь	90%	100%	100%	100%	100%	
5	Хөтөлбөрийн зуны сувилалтай хавсарч хэрэгжүүлсэн байгууллагын тоо	Too	8	10	12	14	17	
6	Хөтөлбөрийн зуны сувилалд хамрагдсан хүүхдийн тоо	Too	384	400	450	500	600	
7	Сургалтад хамрагдсан эцэг эх асран хамгаалагчдын тоо	Too	500	600	700	800	900	
8	Хөтөлбөрт хамрагдаж буй хүүхдүүдийн суурь өвчлөлийн бууруулах хувь	-	-	-	-	-	-	суурь өвчлөл хөтөлбөр эхлэхэд илрүүлээд 6 сарын дараа дахиж илрүүлэх
9	Дэмжлэгт хяналтад хамрагдсан байгууллагын тоо	Too	12	17	17	17	17	
10	Хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	96,5%	100%	100%	100%	100%	

oOo